

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
<p>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/</p>	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/	2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 6-р сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК УБ-ийн дугаар 9007001006 ҮЦ-ны код CUMN Утас 976-7733-0101
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хүнсний дэлгүүр, хүнсний үйлдвэрлэл, худалдааны зуучлал, франчайзын гэрээний үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах, гадаад худалдаа, менежментийн зөвлөх үйлчилгээ
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	817,768,643 ширхэг энгийн хувьцаа
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Д.Бүдханд /Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер/ Хянасан: Г.Чинзориг, Гүйцэтгэх захирал
<p>1. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</p>	
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Нийт хөрөнгө : 177,707,135 мянган төгрөг Нийт өр төлбөр : 178,642,483 мянган төгрөг Эздийн өмч : (935,348) мянган төгрөг
Орлогын тайлан	Борлуулалтын орлого : 167,246,836 мянган төгрөг Нийт алдагдал : 19,372,974 мянган төгрөг
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Хувьцаат капитал (+НТК): 95,597,367 мянган төгрөг Хуримтлагдсан ашиг : (96,851,446) мянган төгрөг
Мөнгөн гүйлгээний тайлан	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал : 8,345,087 мянган төгрөг Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал : (12,054,880) мянган төгрөг Санхүүжилтийн цэвэр мөнгөн урсгал : 1,940,248 мянган төгрөг
<p>2. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</p>	
Энэ маягтад хавсаргав.	

3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Бэлэн мөнгөний цикл 2023 оны 1-р хагаст (21) хоног байсан. Бараа материалын дундаж наслалт 38 хоног болж сайжирсан бол өглөгийн дундаж наслалт 57 хоног байна. Компанийн зүгээс бараа материалын дундаж наслалтыг бууруулах ажлуудыг эхний хагас жилд хэрэгжүүлсний үр дүнд уг үзүүлэлт сайжирсан.
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Компанийн эргэлтийн хөрөнгө нь эргэлтийн өр төлбөрөөс бага буюу эргэлтийн харьцаа 0.6 байна. Компани нь 1-р хагас жилд холбоотой талаас богино хугацаат өглөг авсны үр дүнд уг харьцаа буурсан. Өрийн харьцаа 1.0 болж нэмэгдсэн нь дээрх өглөгөөс гадна дэлгүүрийн тоо нэмэгдэж, санхүүгийн өр төлбөр, зээл нэмэгдсэнтэй холбоотой.
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	2023 оны 1-р хагас жилд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь 40 шинээр салбар дэлгүүр нээж нийт 325 салбартай болоод байна.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Байхгүй
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
		– 2023 оны 2 сарын 16-нд Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болох Премиум Групп ХХК-аас жилийн 18%-ийн хүүтэй, 2 тэрбум төгрөгийн богино хугацаат зээл авч, 2023 оны 5-р сарын 15-нд төлж барагдуулсан.
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
		– Тайлант хугацаанд нэмж хувьцаа гаргаагүй.
6.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл	
		– ТУЗ-ийн хараат бус гишүүн асан Чулууны Мэргэн нь 2022 оны 05-р сарын 31-ны өдөр нас барсан тул түүний оронд Ванчингийн Ганзоригийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ТУЗ-өөс түр томилсонтой холбогдуулан 2023 оны 04-р сарын 29-ний өдөр хуралдуулсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгож

	<p>шинэ бүрэлдэхүүнээр буюу А.Ганхуяг, А.Ганболд, Г.Бат-Эрдэнэ, О.Батмөнх, Б.Бат-Эрдэнэ, Г.Чинзориг нарыг ТУЗ-ийн ердийн гишүүнд, Н.Энхболд, В.Ганзориг, Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нарыг ТУЗ-ийн хараат бус гишүүнд тус тус нэр дэвшүүлсэн бөгөөд тус ээлжит хурлаас дээрх нэр дэвшигчдийг ТУЗ-ийн гишүүдээр томилохоор шийдвэрлэсэн.</p> <ul style="list-style-type: none"> - ТУЗ-ийн хороод нь Авлигын эсрэг үйл ажиллагааны журам, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны журам, Эрсдэлийн удирдлагын заавар, Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, Ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх, шийдвэрлэх журмыг боловсруулан ТУЗ-д танилцуулсан бөгөөд ТУЗ-өөс эдгээр журмуудыг баталж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгосон. - Компанийн охин компани болох Сэнтрал Коммерс ХХК-ийн үйл ажиллагаа нь үр ашиггүй байсан бөгөөд импортын үйл ажиллагаа нь Компанийн стратегийн гол зорилтоос гадуурх функц тул түүний нийт гаргасан хувьцааг худалдсан. - Борлуулалт үйлчилгээний газрын захирал Т.Молор, Санхүүгийн газрын захирал С.Дашдорж нарыг үүрэгт ажлаас чөлөөлсөн бөгөөд Мерчиндайзингийн газрын захирлаар Б.Билгүүнжавыг, Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллероор Д.Бүдхандыг, Борлуулалт үйлчилгээний газрын захирлаар Ц.Номинзолыг, Мэдээллийн технологийн газрын захирлаар Г.Цэрэнжагзанг тус тус томилсон.
--	---


Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Чинзориг

Албан тушаал: Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)




Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.Бүдханд

Албан тушаал: Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Санхүүгийн газрын захирал, Бизнес Контроллер

Гарын үсэг:



--	--	--	--	--	--	--